

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын
2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн
02/112 дугаар албан бичгийн хавсралт



БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 10

Багануур дүүрэг

Д/д	Арга хэмжээ	Биелэлт	Биелэлтийн хувь
1	АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД СУРТАЛЧИЛАХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД		
	1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, гарын авлага, цахим номыг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэргээр олон нийтэд сурталчилж байх	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн талаар 1 төрлийн контент хуваалцсан нь 47 хандалт, 4 хариу үйлдэлтэй, тус газраас Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдэд өгсөн сургалтын мэдээлэл хуваалцсан нь 159 хандалт, 4 хариу үйлдэлтэй, Нийтийн албанд томилогдсон албан хаагчдын ХАСУМ хянасан тухай тойм мэдээг байгууллагын цахим хуудас, албан хаагчдын фэйсбүүк группэд байршуулан мэдээлэл түгээсэн нь 84 хандалт, 5 хариу үйлдэлтэй байна.	80
	1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг салбарын онцлогт тохируулан зохион байгуулах	Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтад улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид байх зарчим, 39 дүгээр зүйлд заасан үйл ажиллагаа явуулахыг хориглох заалт, 49 дүгээр зүйлийн хориглох зүйлс зэргийг танилцуулж, хууль зөрчсөн үйлдэл гаргахгүй байхыг анхааруулсан. Тус газраас төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, мэдээллийг ил тод олон нийтэд нээлттэй хүргэх зорилгоор дүүргийн хүн амын хөдөлмөрийн чадвар алдалтын түвшин, өнөөгийн байдал, Нийгмийн даатгалын шинэчлэлийн асуудлууд, цахим үйлчилгээ сэдвээр тус дүүргийн ИТХ-ын дарга, Засаг дарга, хурлын төлөөлөгчид, хорооны засаг дарга, болон эрүүл мэндийн төв, бусад байгууллагын төлөөлүүдэд илтгэл танилцуулав.	100
	Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг	Багануурын мэдээ сайтад эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаа, хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь, хугацаа тогтоох, хөдөлмөрийн чадвар алдалтын түвшний талаарх мэдээллийг багтаасан контентыг байршуулав. НДЕГ, АТГ-аас бүтээсэн контентыг	100

уриалсан агуулга бүхий контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	албан хаагч нарт танилцуулж ажиллав. Нийт 290 хандалт, 13 хариу үйлдэлтэй байна.	
1.3 Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах, "Шударга ёс, хөгжил дэвшилд-110" мэдээллийн самбарын мэдээллийг тухай бүр шинэчилж, тогтмол ажиллуулах	Газрын мэдээллийн самбарт "Авлигын эсрэг нэгдье 110 дугаар залга" зурагт хуудсыг А4 хэмжээтэй хэвлэж, байрлуулсан. Мөн 2024 оны 05 дугаар сараас хойш Авилгын эсрэг нэгдье зурагт хуудсыг тус газрын фэйсбүүк хуудасны коверт байршуулж, одоог хүртэл тогтмол байрлуулж байна.	90
1.4 Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид болон бусад нийт албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх	АТГ-аас зохион байгуулсан 2 удаагийн сургалтад ЭБАТ оролцож, мэдээлэл авч түгээлээ. Үүнээс гадна хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнээс дээш их хэмжээний өөрчлөлт орсон бол 30 хоногийн дотор мэдээлэх гэсний дагуу нийт албан хаагчдад, түүний дундаас ХАСХОМ гаргагч нарт онцлон сануулж, хууль хэрэгжүүлж ажиллахыг зөвлөв. Мөн газраас зохион байгуулсан сургалтад магадлагч эмч, эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд нийт 10 хүн оролцов.	80
1.5 Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийг танилцуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс зохион байгуулсан Нүдний өвчний орчин үеийн оношилгоо, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, тогтооход анхаарах асуудлууд, Магадлагч эмч нарын тулгамдсан асуудлууд сэдэвт 2 удаагийн сургалтад тус газрын магадлагч эмч болон зөвлөлийн гишүүд оролцов. Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Авилгатай тэмцэх газартай хамтран орон нутгийн Эрүүл мэндийн магадлах зөвлөлийн гишүүдэд Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулсан бөгөөд тус дүүргийн зөвлөлийн 10 гишүүд цахимаар бүрэн хамрагдсан. Үүнээс гадна 2024 онд хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоон судалгааг тус дүүргийн хороо тус бүрээр, хөдөлмөрийн чадвар алдалтын зонхилон тохиолдож буй өвчлөлийн судалгааны сүүлийн 3 жилээр гаргасан судалгааны дүнг олон нийтэд цахимаар хуваалцав. Ингэхэд тус дүүргийн 2-р хорооны иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь улсын дундаж 2,9-өөс их буюу 4.2 байгаа нь анхаарал татаж байгаа тул дүүргийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилж, тус хороонд ажиллаж байна.	100
1.6 Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн дүрэм журмын төслийг судлан, санал хүргүүлэх	Эрх бүхий байгууллагаас ирүүлсэн дүрэм журмын төсөл ирүүлээгүй тул санал хүргүүлээгүй байна.	100
1.7 Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар албан хаагч, олон нийтэд сурталчилах.	Тус газрын мэдээллийн самбар, Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар фэйс бүүк хуудасны коверт "Шударга ёс, хөгжил дэвшилд-110" зурагт хуудсыг тогтмол байршуулж, олон нийтэд сурталчилж байна.	70

	1.8 Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад гарсан аливаа хууль бус үйлдэл, зөрчил, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх.	Хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх үйл явцад ЭММЗ-ийн орлогч даргын бэр эгч ХЧА-н хувь хугацааг шинээр шийдвэрлүүлэх хүсэлт гарсан тул орлогч дарга ашиг сонирхлын зөрчил мэдүүлэх маягт бөглөж, зөвлөлийн даргад мэдэгдсэн. Орлогч даргыг тухайн хүний ХЧА-г тогтооход оролцуулахгүйгээр шийдвэр гаргаж, мэдүүлгийн маягтыг холбогдох иргэний шийдвэрийн хуудсанд хавсаргав.	100
	Дундаж хувь		91,1
2	ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ХҮНД СУРТАЛ, ЧИРЭГДЭЛ БУУРУУЛАХ, ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД		
	2.1.Нийгмийн даатгалын байгууллага болон хувийн хэвшлийн байгууллага хооронд байгуулж буй аливаа гэрээ, хэлэлцээрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар зохицуулалт тусгах.	Тайлант онд тус газраас бараа, ажил үйлчилгээ худалдан авах нийт 7 гэрээ байгуулсан байна. Цаашид "Талууд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй." гэх заалтыг гэрээнд заавал тусгаж байхаар зөвлөв.	50
	2.2 Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Тайлант хугацаанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан 66 төрлийн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд хуулийн хугацаанд байршуулж Baganuur.ndaatgal.mn сайтад оруулсан мэдээллийг shilen.gov.mn сайтад холбоос хаягаар холбож, байгууллагын үйл ажиллагааны 139, нийгмийн даатгалын сангийн 138 мэдээллийг хуулийн хугацаанд оруулан зөрчилгүй ажиллаж байна. Тус газар нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 03/3358 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн Нээлттэй мэдээллийн "SHILEN.GOV.MN" цахим системд нийтэлсэн 1 дүгээр улирлын тайлангийн үнэлгээгээр Чиг үүрэг үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 70%, Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 83%, Төсөв санхүү худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 83%, Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал 73%, Бусад мэдээллийн ил тод нээлттэй байдал 41%, нийт үнэлгээ 74 хувьтай байна.	74
	2.3 Төсвийн орлого, зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын ангиллаар олон нийтэд ил	Төсвийн орлого, зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын ангиллаар олон нийтэд ил тод байршуулж, төсвийн шууд	100

тод байршуулах, төсвийн ерөнхийлэн захирагч, шууд захирагч нарын ерөнхий мэдээллийг байгууллага тус бүрээр албан тушаал, нэрээр ил тод тодорхой болгох, албан тушаал, нэрээр ил тод тодорхой мэдээлэх.	захирагчийн ерөнхий мэдээллийг https://shilendans.gov.mn/ цахим системд албан тушаал, нэрээр ил тод тодорхой мэдээлэв. Тайлант оны 01 дүгээр сараас 05 дугаар сард нийт 382,288.8 мянган төгрөгийн төсвийн орлого авч, түлш халаалт /80101-210302/-ын зардалд 15,240.0 мянган төгрөг гэрэл цахилгаан /80101-210301/-ны зардалд 1,195.1 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн байна.	
2.4 Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл, Ёс зүйн дэд хороо, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, маргаан таслах үйл ажиллагааг сайжруулах, өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх.	Тайлант хугацаанд салбар зөвлөл нь 3 удаагийн хурлаар хортой нөхцөлөөр 1, хүнд нөхцөлөөр 1, тэтгэвэр олгож эхлэх хугацааг тогтоолгох 2, нийт 4 даатгуулагчийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, 3 даатгуулагчийн хүсэлтийг ханган шийдвэрлэж, 1 даатгуулагчийг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласнаар тооцох боломжгүй талаар хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Тус дүүргийн ЗДТГ, Монгол улсын Ёс зүйн хорооны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүү, мэргэжилтнүүдийн хамт зохион байгуулсан Төрийн албан хаагчийн Ёс зүйн хууль тогтоомж сэдэвт танхимын сургалтад тус газрын 16 албан хаагч оролцож мэдлэг, ур чадвараа хөгжүүлэв. Мөн оны 6 дугаар сард НДЕГ-аас зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ сэдэвт сургалтад тус газрын Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд цахимаар оролцов. Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмыг баримтлан ажиллахыг уриалсан постерийг фэйсбүүк хуудаст байршуулж, олон нийтэд хүргэв. Тайлант хугацаанд ёс зүйн талаар гаргасан гомдол хүсэлт байхгүй. Эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн хурал долоо хоног бүрийн Лхагва гарагт Нийгмийн эрүүл мэндийг дэмжих төвд 80-100% ирцтэйгээр, өвчтөний баримт бичгийг үндэслэн нийт 18 удаа хуралдлаа. Хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, хэмжээг 32 иргэнд шинээр тогтоож, 20 иргэний ХЧА-ын хувь хэмжээг цуцалж, 3 шилжиж, 1 иргэн шилжин ирсэн байна. Энэ хугацаанд 210 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааны шийдвэрийг гаргасан бөгөөд энэ оны хагас жилийн байдлаар нийт 896 иргэн хөдөлмөрийн чадвар алдалттай байна.	100
2.5 Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг өргөжүүлэх замаар албан тушаалтнаас хамаарах нөлөөллийг багасгах, эрсдэлд өртөх магадлал, боломжийг бууруулах.	Нийгмийн даатгалын байгууллагын хэмжээнд ашиглаж буй системийг цогц систем болгон нэвтрүүлснээр иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг 100% цахим хэлбэрээр авах боломж, нөхцөлийг бүрдүүлж байна. 2025 оны эхний 5 сарын байдлаар E-Mongolia системээс нийгмийн даатгалын 18 төрлийн үйлчилгээг цахимаар авах боломжтой байна. Энэ чиглэлээр тус газраас постер бэлтгэн олон нийтийн сүлжээнд	100

		байршуулсан нь 1989 хандалт, 10 like, 18 хуваалцал авч, цахим үйлчилгээний боломжийг сурталчилав. Мөн Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ын дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах эрх бүхий байгууллагыг сонгон шалгаруулах зарыг олон нийтийн цахим сүлжээнд нээлттэй байршуулав.	
Дундаж хувь			84,8
3	АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮСЭХ, ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ АРИЛГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД		
	3.1 Тухайн жилд Нийгмийн даатгалын байгууллагаас авлига, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай эрх бүхий байгууллагаас шаардлага хүргүүлсэн, ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн, үүссэн байж болзошгүй тохиолдолд зөрчлийг таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах.	Тус газраас иргэдэд олгох үйлчилгээг 3-5 үе шатаар, харилцан хяналт тогтоож, эргэх холбоо, уялдаатайгаар хүргэж байгаа тул "Авлига, ашиг сонирхлын зөрчил" одоогоор бүртгэгдээгүй байна.	100
	3.2 Шударга байдлын үнэлгээг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллах.	Шударга байдлын үнэлгээ нь гадаад болон дотоод шударга байдал, бодлогод оролцогчдын үнэлгээнээс бүрдэх бөгөөд "Авлигатай тэмцэх газар"-ын захиалгаар "Бодлогын шийдэл" ТББ-ын бэлтгэсэн 2024 оны судалгааны тайланд салбарын дээд байгууллага болох Нийгмийн даатгалын ерөнхий газар гадаад шударга байдал 71,1, дотоод шударга байдал 85,8, бодлогод оролцогчдын үнэлгээ 66,5, нийт 74,5 хувьтай үнэлэгдсэн. Тэгвэл тус газрын хувьд гадаад шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр тайлант хугацаанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан 66 төрлийн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд хуулийн хугацаанд байршуулж Baganuur.ndaatgal.mn сайтад оруулсан мэдээллийг shilen.gov.mn сайтад холбоос хаягаар холбож, байгууллагын үйл ажиллагааны 139, нийгмийн даатгалын сангийн 138 мэдээллийг хуулийн хугацаанд оруулан зөрчилгүй ажиллаж байна. Тус газар нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 03/3358 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн Нээлттэй мэдээллийн "SHILEN.GOV.MN" цахим системд нийтэлсэн 1 дүгээр улирлын тайлангийн үнэлгээгээр 74 хувьтай байна. Дотоод шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр тус газрын дарга Нийгмийн даатгалын ерөнхий газар, дүүргийн Засаг даргын	82,8

	удирдах ажилтнуудын шуурхай хуралдаанд өгөгдсөн мэдээлэл, үүрэг даалгаврыг нийт албан хаагчдад тухай бүр танилцуулж ажиллав.	
3.4 Төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, журам, дүрэм нь авлига, ашиг сонирхлын зөрчил гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн гэж үзвэл төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж, хүчингүй болгуулах санал хүргүүлэх, өөрийн байгууллагын гаргасан тушаал шийдвэрт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох.	Дүүргийн Нийгмийн даатгалын газар нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт гаргахгүй байгаа, албан тушаалтнууд, хороо, зөвлөлийн гаргасан шийдвэрийг хууль, эрхзүйд нийцүүлэн гаргахад байнга анхааран ажиллаж, тайлант хугацаанд энэ төрлийн тохиолдол гараагүй.	100
Дундаж хувь		94.2
Нийт дундаж хувь		90,0

ХЯНАСАН:
ГАЗРЫН ДАРГА

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
ЭРХ БҮХИЙ АЛБАН/ТУШААЛТАН





Р.ӨНӨРЖАРГАЛ



Г.БАТБОЛД

БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАНГИЙН НОТЛОМЖ БАРИМТУУД

1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, гарын авлага, цахим номыг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэргээр олон нийтэд сурталчилж байх

1. АТГ-н фэйсбүүк хуудаснаас хуваалцсан нийтлэлүүд






1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг салбарын онцлогт тохируулан зохион байгуулах







1.2.1 Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх



1.3 Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах, “Шударга ёс, хөгжил дэвшилд-110” мэдээллийн самбарын мэдээллийг тухай бүр шинэчилж, тогтмол ажиллуулах



1.4 Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид болон бусад нийт албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх
1.5 Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль тогтоомжийг танилцуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах



1.7 Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар албан хаагч, олон нийтэд сурталчилах



2.1. Нийгмийн даатгалын байгууллага болон хувийн хэвшлийн байгууллага хооронд байгуулж буй аливаа гэрээ, хэлэлцээрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар зохицуулалт тусгах.



1.2 Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

Нүүр / Индексийн тайлан / Багануур дүүргийн нийгмийн даатгалын газар

Багануур дүүргийн нийгмийн даатгалын газар

Буцах

Тайлант үе:
2025 оны 1 улирал

№	Бүлгийн нэр	Шалгуур үзүүлэлтийн оноо				Нийт оноо	Хувь	
		МХБ	ХНБ	МБББ	ЭСТБ			
+	1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	380	450	370	150	1,350/ 1,920	70.31%
+	2	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	210	210	210	70	700/ 840	83.33%
+	3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	300	300	280	120	1,000/ 1,200	83.33%
+	4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал	75	90	70	30	265/ 360	73.61%
+	5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	30	30	30	10	100/ 240	41.67%

1.3 Төсвийн орлого, зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын ангиллаар олон нийтэд ил тод байршуулах, төсвийн ерөнхийлэн захирагч, шууд захирагч нарын ерөнхий мэдээллийг байгууллага тус бүрээр албан тушаал, нэрээр ил тод тодорхой болгох, албан тушаал, нэрээр ил тод тодорхой мэдээлэх.

Нүүр

Байгууллага

Засгийн газрын тусгай сан

Нээлттэй өгөгдөл

Оралцахуй

Багануур дүүргийн нийгмийн даатгалын газар

И-мэйл:
Ажлын утас:
70210021

Шуудангийн хаяг:
Сошиал хаяг:

Далгавангүй нээлэл
Салбар байгууллагууд

Нэр тэмдгээр тайлбар

ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Буцах

Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт - эдийн засгийн ангилал

Он: 2025

Улирал: 1

Сар: 2-р сар

Мэдээллийн төрөл:

Датумж: Сар бүр

Мэдээлэл оруулах хугацаа: 2025-03-08

Тайлан

Хавсаргасан файл

Мэдээлэл оруулсан огноо: 2025-03-07 13:44:33

Дансны дугаараар шүүж харах:

№	Длис. №	ЗЛА мод. №	Эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв жилээр	Батлагдсан төсөв тайлант үе /өсөв дундаар/	Батлагдсан төсөв гүйцэтгэл /өсөв дундаар/	Батлагдсан төсөв тайлант үе /савар дундаар/	Батлагдсан төсөв гүйцэтгэл /савар дундаар/	Төлөв
1	10020029001-0	122005	ТЭНДЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ			25,404,305.71 ₮		9,983,934	✓
2	10020029001-0	122005	АЛБАТДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХҮҮСЭВ			-25,404,305.71 ₮		-9,983,934	✓
3	10020029001-0	122005	Харилцах болон хадгалангийн дансны цуврал өөрчлөлт			-25,404,305.71 ₮		-9,983,934	✓
4	10020029001-0	122005	Мөнгөн хөрөнгийн заргийн нэгдсэн			25,404,305.71 ₮		9,983,934	✓
5	10020029001-0	122005	НИЙТ ОРЛОГО БА	966,724,400.00 ₮	153,886,400.00 ₮	153,886,400.00 ₮	76,435,800.00 ₮	77,435,800	✓

1.4 Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл, Ёс зүйн дэд хороо, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, маргаан таслах үйл ажиллагааг сайжруулах, өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх.



1.5 Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг өргөжүүлэх замаар албан тушаалтнаас хамаарах нөлөөллийг багасгах, эрсдэлд өртөх магадлал, боломжийг бууруулах.

 **Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар** May 8 · 🌐

◆ "Цахим үйлчилгээ - Цагийг хэмнэнэ"
◆ "Нийгмийн даатгалын 18 төрлийн үйлчилгээг – Хаанаас ч, хэзээ ч!"

Нийгмийн даатгалын 18 төрлийн үйлчилгээг  -аас 🕒 харгалзахгүй  авах боломжтой.

1. Иргэн (Даатгуулагч)-д нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсвэрийг тухай тодорхойлолт
2. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт
3. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа
4. Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт
5. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлт
6. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлт
7. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт
8. Нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийн буцаан олголт авах дансны дугаар холбох, засах
9. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас
10. Өндөр насны тэтгэвэр тогтоолтын хуудас
11. Тэнгэрчээ алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас
12. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт /англи/
13. Өндөр насны тэтгэвэр тогтоолтын хуудас (англи)
14. Тэнгэрчээ алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас (англи)
15. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас (англи)
16. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас (англи)
17. Сайн дурын даатгуулагчаар бүртгүүлэх хүсэлт
18. Тэтгэвэрээ 5 жилийн дундаж цалин хөлсөөр нэг удаа өөрчлөн тогтоолгох хүсэлт

🏠 ГЭРЭЭСЭЭ – АЖИЛ, АМЬДРАЛД СААДГУЙ 📄 ЦАХИМААР - ХУРДАН, ХЯЛБАР, НАЙДВАРТАЙ

👍 10 💬 🔄 📌 18

Нийгмийн даатгалын 18 төрлийн үйлчилгээг  -аас 🕒 харгалзахгүй  авах боломжтой.

1. Иргэн (Даатгуулагч)-д нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсвэрийг тухай тодорхойлолт
2. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт
3. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа
4. Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт
5. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлт
6. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлт
7. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт
8. Нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийн буцаан олголт авах дансны дугаар холбох, засах
9. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас
10. Өндөр насны тэтгэвэр тогтоолтын хуудас
11. Тэнгэрчээ алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас
12. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт /англи/
13. Өндөр насны тэтгэвэр тогтоолтын хуудас (англи)
14. Тэнгэрчээ алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас (англи)
15. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас (англи)
16. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас (англи)
17. Сайн дурын даатгуулагчаар бүртгүүлэх хүсэлт
18. Тэтгэвэрээ 5 жилийн дундаж цалин хөлсөөр нэг удаа өөрчлөн тогтоолгох хүсэлт

🏠 ГЭРЭЭСЭЭ – АЖИЛ, АМЬДРАЛД СААДГУЙ 📄 ЦАХИМААР - ХУРДАН, ХЯЛБАР, НАЙДВАРТАЙ